

## **ХЭХТ-ийн харьяа Дархан-Уул аймгийн Зулзагын Хөгжил МХБ-ийн үйл ажиллагааны товч тайлан**

Хүний эрх хөгжил төвийн харьяа “Зулзагийн Хөгжил” мөнгөн хуримтлалын бүлэг нь 2011 оны 02р сарын 27 нд анх 8 гишүүнтэйгээр анх үүсэн байгуулагдсан. Одоогоор 10 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

### **Зулзагын хөгжил МХБ-ийн зорилго**

Зулзагийн хөгжил мөнгөн хуримтлалын бүлгийн гишүүд бид өөрсдийн хүчээр ажлын байр бий болгон, орлогоо нэмэгдүүлэх, хуримтлал үүсгэж амжиргаагаа дээшлүүлэх, амьдарч буй газар нутаг, ой, бэлчээр, ууж ундаалдаг Зулзагын голоо эзний ёсоор хайрлан хамгаалж үр хойчдоо өвлүүлэн үлдээх **ЗОРИЛГОТОЙ**

### **Зулзагын Хөгжил МХБ-ийн**

#### **Дотоод дүрэм**

- 1. Хуримтлалын мөнгийг сар бүр нэг гишүүн 5000 төгрөг бүлгийн санд хуримтлуулна*
- 2. Хуримтлалын мөнгийг сар бүрийн 15-25 багтаан тушаана.*
- 3. Бүлгийн хурлыг сондгой тоотой сар бүрийн 2 дахь 7 хоногийн бүтэн сайнд өдөр 12 цагт хийнэ. Хуралаас хоцорсон шалтгаангүй тасалсан тохиолдолд торгуультай*
- 4. Бүлгээс зохиосон ажилд гишүүн бүр идэвхитэй оролцоно*
- 5. Бүлгийн гишүүд бүлгээс зээл авахад 1-3 сарын хугацаатай 2% хүтэй олгож байх*
- 6. Бүлгийн гишүүн бүлгээс гарах үед хуримтлалын мөнгөнөөс буцаан олгогдохгүй*

“Зулзагын хөгжил “ МХБ

- ✓ Спорт хувцасны оёдлын чиглээр үйл ажиллагаа явуулдаг -1 гишүүн
- ✓ Үндэсний монгол хувцасны оёдол болон гахайн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг -1 гишүүн
- ✓ Хүнсний жижиглэн худалдаа лангуу ажиллуулдаг болон хүнсний ногоо тариалдаг -1 гишүүн
- ✓ Мал аж ахуй эрхэлдэг – 7 гишүүн. Нийт -10 гишүүнтэй

“Зулзагын Хөгжил” МХБ-ийн гишүүд хамтран жилдээ нэг удаадаа

- ✓ Блок үйлдвэрлэх
- ✓ Хадлан хадах
- ✓ Халиар түүн дарж худалдах
- ✓ Ногоо тариалах замаар бүлэгтээ орлого олдог
- ❖ Дундын сангаа богино хугацаанд өсгөх зорилгоор байгалаас жимс, мөөг, халиар түүж борлуулан олсон орлогоороо жижиг оврын 220 –оор ажилладаг блокны машин 750 мянган₮ өөр худалдан авч 2011 оны 10 сард блокын үйлдвэртэй болсон.
- ❖ 2012 онд Хүний эрх хөгжил төв төрийн бус байгууллагаас нийт 6 сая төгрөгийн төслийн зээл олгосноос 4 сая төгрөгөөр гишүүдийн малын байр өвөлжөөг засаж сэлбэж сайжруулсан, 2 айлд

шинээр төл малын байр барьж 1 сая 500 мянган төгрөгөөр 20\*6 хэмжээтэй хүлэмж барьсан, 500 мянган төгрөгөөр блокоо үйлдвэрлэхэд шаардлагтай материалын зарим хэсгийг худалдан авахад зарцуулж уг төслийг амжилттай хэрэгжүүлж бүлгийн болон гишүүдийн чадавхыг бэхжүүлэхэд үр дүнтэй ажил болсон.

- ❖ 2013 онд Хүний эрх хөгжил төвөөс 4 сая 500 мянган төгрөгийн төсөлд хамрагдснаас хадлан төсөлд 1 сая төгрөгийг зарцуулж боодлын өвс бэлтгэн борлуулж хуримтлалаа өсгөн бол үлдсэн 3 сая 500 мянган төгрөгөөр бүлгийн гишүүн бүх өрхийг нэг өнгө загварын жорлонтой болгож жигдрүүлэх ажил хийсэн.
- ❖ 2014 онд хүний эрх хөгжил төвөөс нийт 11 сая төгрөгийн зээлд хамрагдснаас 3 сая төгрөгийн малын шим төсөл хэрэгжүүлсэн бөгөөд энэ ажлаар бид бяруу, шүдлэн үхэр худалдан авч маллан өвлийн улиралд мах бэлтгэн борлуулж зарим хэсгийн бүлгийн дундын мал аж ахуйг үүсгэх зорилгоор эм үхрүүдийг маллах ажлыг эхлүүлж байсан
- ❖ 3 сая төгрөгөөр өмнөх жилүүдэд хийж туршлагжсан хадлан бэлтгэх ажлаар өөрийн хэрэгцээний өвс тэжээл бэлтгэхээс гадна зарж борлуулах ажлыг хийсэн.
- ❖ Орон байр сайжруулах 5 сая төгрөгөөр нэг өрхийн зуны байшинг 2 давхар болгож засаж тохижуулсан.
- ❖ 2016 онд бид блокын цехээ өргөтгөх зорилгоор Хүний эрх хөгжил төвөөс 3 сая төгрөгийн хүүгүй зээлд хамрагдаж 380 аар ажиллах цахилгаан үүсгүүр, 1 удаад 4 ширхэгээр блок гаргах блокын машин 100 ширхэг поддон, блокын тэрэг, зуурмагын машин зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч жилд үйлдвэрлэн борлуулах блокын тоог нэмэгдүүлж ажиллсан.

Зулзагын хөгжил мөнгөн хуримтлалын бүлэг нь хүний эрх хөгжил төвөөс зарлан зохион байгуулсан туршлага солилцох зуны чуулга уулзалтанд нийт 8 удаа оролцсноос 2 удаагийн уулзалтыг Дархан уул аймагтаа амжилттай зохион байгуулсан.

Мөн бусад уулзалт сургалт арга хэмжээнд байнга идэвхитэй оролцож уг арга хэмжээнээс сурч, олж мэдсэн зүйлээ бүлэг болон гишүүнийг чадавхижуулахад зориулан ажиллаж байна.

Зулзагын хөгжил бүлэг нь дээр дурьдсан ажлуудаас гадна Орон нутгийн засаг захиргаа, аймаг, сум багийн удирдлага, хувийн хэвшил, хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, монгол улсад хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байна.

Хонгор сумын засаг даргын тамгын газар бүлгийн санхүүг нэмэгдүүлэн үндсэн хөрөнгө бий болгох цаашид сум багаас зохиогдож байгаа ажлыг хамтран хийж байх зорилгоор Амралт зуслангын зориулалтын 1 га газар олгож бидэнд дэмжлэг үзүүллээ.

#### **Зулзагын хөгжил мөнгөн хуримтлалын бүлэгийн гишүүдийн дундын хөрөнгө**

- Блокны машин – 1 ширхэг
- 380 вольтын цахилгаан үүсгүүр -1 ширхэг
- Пад трактор 4- ширхэг
- Зуурмагын машин -1 ширхэг
- Хадуур тармур -1 ширхэг
- Төмс хүнсний ногооны талбай – 8 га

- Амралт сувилалын зөвшөөрөлтэй газар зэрэг дундын хөрөнгө бүрдүүлж цаашид бүлгийн гишүүд болон хуримтлалын хэмжээг нэмэгдүүлэх зорилготой хамтран ажиллаж байна.

**Зулзагын хөгжил МХБ- нь нийгмийн хариуцлагийнхаа хүрээнд дараах хандив, тусламж өгч байсан.**

- Бүлгийн ахмад гишүүддээ жилд 1 хүнд сар шинийн баяраар 100.000₮
- Малын халдварт шүлхий өвчний үед хонгор сумын малчдад хандив 100.000₮
- 2р багийн өндөр настанд 100.000₮
- Багийн байр барихад 100 ширхэг блок
- Сумын иргэдийн хуралд гар бөмбөгийн багийн өмсгөл 8 ширхэгийг хийж өгсөн
- Бүлгээс нас барсан 2 гишүүний ар гэрт буцалтгүй тусламж 800.000₮
- Өвөрхангай аймгийн гишүүн Мятавдорж хүүхдийн эмчилгээнд 100.000₮ хандив
- Бүлгийн гишүүний хүүхэд нас бархад гишүүнд- 120.000₮
- Хэнтий аймгийн мөрөн сумын өндөр настан Доржготов -60.000
- Өвөрхангай аймгийн гишүүн Эрдэнэбаярт – 40.000
- Бүлгийн 4 гишүүн байшин барихад 400.000 ₮

**Зулзагын хөгжил МХБ-ийн авч хэрэгжүүлсэн санхүүжилт**

- ✓ ХЭХТ төрийн бус байгууллагын 14 удаагийн 30.500.000 ₮ зээл төсөл
- ✓ Сум орон нутаг Хөдөлмөрийн хэлтэс төсөл хөтөлбөрүүдийн 7.4796.000 ₮ санхүүжилт авч хэрэгжүүлсэн

**Зулзагын хөгжил МХБ ХЭХТ- өөс олгогдсон санхүүжилт төслүүд**

№	Он	Төслийн нэр	Мөнгөн дүн	Хүү
1	2012 онд	Бүлэг чадавхижуулах зээл	500,000	1.5 %
2	2012 онд	Хүлэмж төлсөл	1500.000	1.5%
3	2012 онд	Малын байр төсөл	4.000.000	Хүүгүй
4	2013 онд	Хадлан төсөл	1.000.000	1.5 %
5	2013 онд	Эко төсөл	3.500.000	1.5 %
6	2014 онд	Малын шим тэжээл төсөл	3.000.000	1%
7	2014 онд	Хадлан төсөл	3.000.000	1%
8	2014 онд	Орон байр төсөл	5.000.000	1.5 %
9	2015 онд	Гишүүн дэмжих зээл	1.000.000	1.5 %
10	2015 онд	Гишүүн дэмжих зээл	2.000.000	1.5 %
11	2016 онд	Блок төсөл	3.000.000	Хүүгүй
12	2016 онд	Гишүүнд буцалтгүй тусамж	500 \$	
13	2018 онд	Дээвэр төсөл	1.000.000	1.5 %
14	2018 онд	Хашаа төсөл	1.000.000	1.5%
		<b>Нийт</b>	<b>30.500.000 төг</b>	

**Зулзагын хөгжил бүлгийн гишүүдийн хэрэгжүүлсэн төслүүд:**

**Гишүүн дэмжих 2 сая төгрөг 2016 он.** Ц. Жавзандулам, Ц. Цэнд-Аюуш нар Дархан сүлд спорт хувцас\ БЭЭЖИН хотоос хэвлэх машин, Даавуу материал татаж байсан



**ЭКО төслөөр 2013 онд\ 350.000 мянган төгрөг\**бүлгийн гишүүн бүх өрхүүд нэг өнгө загварын оотой болсон



**Орон байр төсөл 2014 онд 5 сая төгрөг.** Гишүүн Төмөртөдөг орон байр төслөөр барьсан Зуслангийн байшин



**Буцалтгүй 500\$** т у с л а м ж . Б . О ч и р в а а н ь з у с л а н г и й н б а й ш и н  
б а р ь с а н



2016 онд Сум орон нутгаас хог цэвэрлэгээ төсөл хэрэгжүүлж бүлгийн санд 900,000 бүлгийн гишүүд хамтран ажлыг хийж гүйцэтгэсэн.





2018 онд 1 сая төгрөг \Хашаа Төслөөр барьсан хашаа\ гишүүн Эрдэнэсайхан, Баасанжав\



2018 онд 1 сая төгрөг байшингийн дээвэр төсөл. Гишүүн Ц.Жавзандулам



**Зулзагын хөгжил МХБ-ийн гишүүдийн хамтын хөдөлмөр**

**Хадлангийн ажил:**



**Блок үйлдвэрлэл**





**Ногооны ажил**



**Халиар /Зун нь түүж даршлаад газарт булж хадгалаад намар гаргаж байгаа нь/**



Бүлгийн малчин гишүүд:





Гишүүн Б.Төмөртөдөгийн хувийн бизнес: хүнсний жижиглэн худалдааны лангуу, хүнсний ногоо тариалалт



Гишүүн Ц. Жавзандуламын хувийн бизнес \гэртээ оёдол, гахайн аж ахуй, дарсан ногоо



Гишүүн Ц. Цэнд-Аюушын “Дархан Сүлд” спорт хувцасны Захиалгат оёдол





Зулзагын хөгжил МХБ-ийн гишүүд амралтын газар байгуулах газартаа хэмжилт хийж байгаа нь





Тайланг гаргасан:

Зулзагийн хөгжил МХБ-ийн

Ахлагч Б.Төмөртөдөг

2021оны 01 сарын24